

**Холбогдох байгууллагын санал:**

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
С.Дансанийн гудамж 5/1, Засгийн газрын 4 байр
Утас/факс: (976-51) 26 74 88 нэр /www.mongolstat.audit.mn/

2018.12.14 № 13-1/7877
танай _____-ны М _____-г

Аудитын тайлангийн төсөлд
хариу хүргүүлэх тухай

“Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”-д хийсэн Нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Аудитын тайлангийн төсөлд тусгайлан өгөх саналгүй болно.


Төсвийн ерөнхийлөн захирагч нарын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, удирдлага арга зүйгээр хангах, сургалт хийх зэрэг ажлуудыг тогтмол хийж ирсэн бөгөөд ирэх онд манай яамнаас хийх 2018 оны шилэн дансны хуулийн хэрэгжилтийн тайланг танай газарт хүргүүлж ажиллана.

Шилэн дансны тухай хууль болон холбогдох журмын өөрчлөлт, системийн шинэчлэл зэрэг ажлуудыг зайлшгүй хийх шаардлагатай байгаа бөгөөд эдгээр ажлуудад танай байгууллагын саналыг тусган хамтран ажиллахаар төлөвлөж байна.

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ЭРСДЭЛИЙН
УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГА

Б.ДОРЖСЭМБЭД

11156



ШИЛЭН ДАНСНЫ НЭГДСЭН ЦАХИМ ХУУДАСНЫ ХЭРЭГЛЭГЧИЙН САНАЛ АСУУЛГЫН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

2018 оны 11 дүгээр сар



АГУУЛГА

ХУРААНГУЙ.....	3
ШИЛЭН ДАНСНЫ НЭГДСЭН ЦАХИМ ХУУДАСНЫ ХЭРЭГЛЭГЧИЙН САНАЛ АСУУЛГЫН СУДАЛГААНЫ ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА.....	4
I. НЭГ ТАЛТ СУДАЛГААНЫ ТАЙЛАН.....	6
1.1 ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	6
1.2 ШИЛЭН ДАНС БОЛОН ШИЛЭН ДАНСНЫ НЭГДСЭН ЦАХИМ ХУУДАСНЫ ТАЛААРХ ИРГЭДИЙН ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ	8
1.3 ШИЛЭН ДАНСНЫ НЭГДСЭН ЦАХИМ ХУУДАСНЫ АШИГЛАЛТ	9
1.4 ШИЛЭН ДАНСНЫ НЭГДСЭН ЦАХИМ ХУУДАС, БАЙРШУУЛСАН МЭДЭЭЛЭЛД ӨГӨХ ҮНЭЛГЭЭ.....	14
1.5 ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ИРГЭНИЙ ХЯНАЛТ	17
II. ХОЁР ТАЛТ СУДАЛГААНЫ ТАЙЛАН.....	18
III. ДҮГНЭЛТ.....	21

Хавсралт 1: Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны хэрэглэгчийн санал асуулга

Хавсралт 2: Судалгаа авах явцад гарсан бэрхшээл, асуудлууд



ЗУРГИЙН ЖАГСААЛТ:

Зураг 1.2.1 Шилэн дансны талаарх иргэдийн ойлголт, мэдлэг

Зураг 1.2.2 Улс, орон нутгийн болон төсвийн байгууллагын төсвийн мэдээллийг иргэд авч буй эх сурвалж

Зураг 1.2.3 Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны талаарх иргэдийн ойлголт, мэдлэг

Зураг 1.3.1 Шилэн дансны нэгдсэн цахим хуудаснаас иргэд аль байгууллага, этгээдийн төсвийн мэдээлэл авдаг талаарх мэдээлэл

Зураг 1.3.2 Шилэн дансны нэгдсэн цахим хуудаснаас иргэд авдаг мэдээллийн төрөл

Зураг 1.3.3 Шилэн дансны нэгдсэн цахим хуудаснаас иргэд Засгийн газрын төсвийн талаарх ямар мэдээлэл авдаг талаарх мэдээлэл

Зураг 1.3.4 Шилэн дансны нэгдсэн цахим хуудаснаас иргэд төсвийн санхүүжилттэй худалдан авалтын мэдээлэл авдаг байдал

Зураг 1.3.5 Шилэн дансны нэгдсэн цахим хуудаснаас иргэд авдаг бусад мэдээлэл

Зураг 1.3.6 Шилэн дансны нэгдсэн цахим хуудаснаас иргэд мэдээлэл авдаг давтамж

Зураг 1.4.1 Шилэн дансны нэгдсэн цахим хуудас хуулийн шаардлагыг хангаж байгаа эсэхэд иргэдээс өгсөн үнэлгээ

Зураг 1.4.2 Шилэн дансны нэгдсэн цахим хуудас дахь мэдээлэлд иргэдээс өгсөн үнэлгээ

Зураг 1.4.3 Шилэн дансны нэгдсэн цахим хуудсыг сайжруулах шаардлагатай эсэх талаарх иргэдийн санал

Зураг 1.5.1 Шилэн дансны мэдээллийг иргэд ямар зорилгоор авдаг талаар

Зураг 1.5.2 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн явц, зөрчлийн талаар иргэд гомдол, шаардлага гаргаж байсан байдал

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ:

Хүснэгт 2.1 Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны талаарх иргэдийн ойлголт, мэдлэгийг насаар ангилсан байдал

Хүснэгт 2.2 Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны талаарх иргэдийн ойлголт, мэдлэгийг хүйсээр ангилсан байдал

Хүснэгт 2.3 Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны талаарх иргэдийн ойлголт, мэдлэгийг боловсролын түвшингээр ангилсан байдал

Хүснэгт 2.4 Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны талаарх иргэдийн ойлголт, мэдлэгийг ажил эрхлэлтийн байдлаар ангилсан байдал

Хүснэгт 2.5 Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны талаарх иргэдийн ойлголт, мэдлэгийг дүүргээр ангилсан байдал



ХУРААНГУЙ

Төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх зорилго бүхий Шилэн дансны тухай хууль 2015 оноос хэрэгжиж байна. Уг хуулийн хүрээнд Засгийн газраас шилэн дансны нэгдсэн цахим хуудсыг бий болгон улс, орон нутгийн төсвийн орлого, зарлага, худалдан авалт, холбогдох шийдвэр зэрэг мэдээллүүдийг нийтэд ил болгох үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа юм. Үндэсний Аудитын Газартай байгуулсан гэрээний дагуу Нээлттэй нийгэм форумаас иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран шилэн дансны нэгдсэн цахим хуудасны хэрэглэгчийн санал асуулгын судалгааг нийслэлийн 3 дүүргийн 600 гаруй иргэнийг хамруулан хийлээ.

Судалгаагаар шилэн данс болон шилэн дансны нэгдсэн цахим хуудасны талаарх иргэдийн ойлголт, мэдлэг, улс, орон нутгийн болон төсвийн байгууллагын төсвийн мэдээллийг иргэд авч буй эх сурвалж, шилэн дансны нэгдсэн цахим хуудаснаас иргэдийн авдаг мэдээллийн төрөл, цахим хуудас дахь мэдээллийн чанарын талаар иргэдээс асуулга авав. Үүний зэрэгцээ уг цахим хуудас Шилэн дансны тухай хууль, журамд заасан шаардлагыг хангаж байгаа эсэх, түүнийг сайжруулах шаардлагатай эсэх талаар иргэдийн саналыг судлав. Цаашилбал, иргэд Шилэн дансны тухай хуулийн тухай хэрэгжилтийн явц, зөрчлийн талаар гомдол, шаардлага гаргаж байсан эсэх, тэдгээр нь шийдвэрлэгдсэн эсэх талаар иргэдээс судалгаа авлаа. Судалгааг бид 2018 оны 11 дүгээр сард гүйцэтгэв.

Нийслэлийн Баянгол, Баянзүрх, Чингэлтэй дүүргийн иргэдийн дунд хийсэн энэхүү судалгааны дүнгээр шилэн дансны нэгдсэн цахим хуудасны талаар иргэдийн мэдлэг, мэдээлэл дутмаг байгаа нь харагдав. Тухайлбал, судалгаанд хамрагдсан иргэдийн 55% нь шилэн дансыг “бага зэрэг мэднэ”, гэж хариулсан бол зөвхөн 8% нь “сайн мэднэ” гэжээ. Цаашилбал, Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны талаар иргэдийн 32.5% нь “бага зэрэг мэднэ”, гэсэн бол зөвхөн 6% нь “сайн мэднэ” гэжээ. Судалгаанд хамрагдсан иргэдийн зөвхөн 6% нь улс, орон нутгийн болон төсвийн байгууллагын төсвийн талаарх мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаснаас авдаг байна. Шилэн дансны цахим хуудаснаас мэдээлэл авдаг иргэд мэдээллийн үнэн зөв, бодитой, иж бүрэн байдал, ойлгомжтой, ач холбогдолтой байдал, тогтоосон хугацаандаа мэдээлдэг байдал болон хуулийн дагуу нууцад хамруулсанаас бусад бүх мэдээллийг нээлттэй байршуулдаг байдалд “дунд” гэсэн үнэлгээ өгсөн байна. Судалгаанд хамрагдсан иргэдийн 1.6% нь Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилийн явц, зөрчлийн талаар гомдол болон шаардлага гаргаж байсан байна.

Судалгааны дүнгээс харахад, төсвийн удирдлагад олон нийт хяналт тавих үйл ажиллагааг дээшлүүлэхийн тулд Шилэн дансны тухай хууль болон шилэн дансны нэгдсэн цахим хуудсыг иргэдэд таниулах ажлыг төр засгийн зүгээс хийх шаардлагатай байна.




ШИЛЭН ДАНСНЫ НЭГДСЭН ЦАХИМ ХУУДАСНЫ ХЭРЭГЛЭГЧИЙН САНАЛ АСУУЛГЫН СУДАЛГААНЫ ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

Судалгааны хамрах хүрээ, түүвэрлэлт: Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны хэрэглэгчийн санал асуулгын судалгаанд Нийслэлийн Баянзүрх, Баянгол, Чингэлтэй дүүргүүдийг хамрууллаа. Үүнд, Баянзүрх дүүргээс 278 иргэн, Баянгол дүүргээс 204 иргэн, Чингэлтэй дүүргээс 134 иргэн хамрагдав.

Санал асуулгад хамруулсан иргэдийн тоо (дүүргээр)



Судалгаанд хамрагдах иргэдийн түүврийн хэмжээг дүүрэг бүрт бүртгэлтэй насанд хүрсэн иргэдийн тоон дээр суурилан 95 хувийн итгэх түвшин, 4 хувийн алдааны магадлалтайгаар тооцож түүврийг 581 байхаар төлөвлөсөн болно. Харин судалгаанд дутуу болон алдаатай бөглөсөн асуулга гарах эрсдэлийг тооцож 650 иргэнээс судалгааг авч, бүрэн бөглөсөн 616 судалгааны асуулга дээр боловсруулалт хийлээ.





Судалгаанд нийгмийн бүх давхрагыг хамруулах, бодит байдлыг хангахын тулд түүврийн тоо хэмжээг тухайн дүүрэг тус бүрээр үндсэн 4 зорилтот сегментээр тодорхойлон авсан болно.

Дүүрэг	Судалгаанд хамруулах иргэдийн тоо	Дүүргийн харьяа орон сууц -30%	Дүүргийн харьяа ААН, үйлчилгээний төвүүд - 15%	Дүүргийн харьяа боловсролын байгууллага -15%	Дүүргийн засаг захиргааны байр - 40%
Баянгол дүүрэг	179	54	27	27	72
Чингэлтэй дүүрэг	129	39	19	19	52
Баянзүрх дүүрэг	273	82	41	41	109
Нийт	581	174	87	87	232

Судалгааны арга зүй, мэдээлэл боловсруулалт: Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны хэрэглэгчийн үнэлгээний мэдээллийг санал асуулгын аргаар цуглуулсан болно. Үнэлгээг 5 бүлэг, 26 асуулт (Хавсралт-1) бүхий санал асуулгаар тодорхойлсон. Үүнд:

- **1-р бүлэг.** Шилэн данс болон шилэн дансны нэгдсэн цахим хуудасны талаарх иргэдийн ерөнхий ойлголт
- **2-р бүлэг.** Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны ашиглалт
- **3-р бүлэг.** Шилэн дансны нэгдсэн цахим хуудас, байршуулсан мэдээлэлд иргэдээс өгөх үнэлгээ
- **4-р бүлэг.** Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд тавих иргэний хяналт
- **5-р бүлэг.** Ерөнхий мэдээлэл гэсэн бүтэцтэй.

Судалгааны мэдээлэл боловсруулалт, шинжилгээг нийгмийн судалгааны статистик шинжилгээ хийх багц програм болох SPSS21 програм хангамжийг ашигласан бөгөөд мэдээллийн шинжилгээний боломжит дүнгүүд, тухайлбал асуулга бүрийн дүнг харуулсан нэг талт судалгааны дүнг тайлбарлах болон судалгааны асуулгыг ерөнхий мэдээлэлтэй харьцуулсан хоёр талт судалгааны тайлан бүхий статистикийн дүнг гаргасан болно.

Судалгаа авах явцад гарч байсан хүндрэлүүдийн талаар Хавсралт 2-оос үзнэ үү.



I. НЭГ ТАЛТ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

1.1 ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны хэрэглэгчийн санал асуулгад нийслэлийн 3 дүүргийн 650 иргэн хамрагдсанаас алдаагүй, бүрэн гүйцэт бөглөсөн 616 судалгааны асуулга дээр боловсруулалт хийж, дүнг гаргалаа. Баянзүрх дүүргээс 278 иргэн, Баянгол дүүргээс 204 иргэн, Чингэлтэй дүүргээс 134 иргэн хамрагдсанаас 55.2% нь эмэгтэй, 44.8% нь эрэгтэй байсан.

Санал асуулгын судалгааны ажлын явцын зураг



Насны хувьд, судалгаанд хамрагдсан иргэд насны суваргын дагуу жигд түүвэртэй хамрагдаж чадсан байна. Боловсролын хувьд, нийт судалгаанд хамрагдсан иргэдийн 67.2% нь дээд боловсролтой байна. Харин ажил эрхлэлтийн хувьд 39.3% нь хувийн хэвшил, 20.8% хувиараа хөдөлмөр эрхлэгч, 18.2% нь төрийн байгууллагын ажилтнууд хамрагдсан байна.



Судалгаанд оролцогсдын ерөнхий мэдээлэл


	Оролцогчдын тоо	Дүнд эзлэх хувь		Оролцогчдын тоо	Дүнд эзлэх хувь
1. Хүйс			4. Ажил эрхлэлт		
эрэгтэй	276	44.8	Төрийн байгууллага	112	18.2
эмэгтэй	340	55.2	Хувиараа хөдөлмөр эрхлэгч	128	20.8
2. Нас			Хувийн хэвшил	242	39.3
20-24	66	10.7	Олон улсын байгууллага	6	1.0
25-29	84	13.6	Эрхэлсэн ажилгүй	54	8.8
30-34	90	14.6	Оюутан	28	4.5
35-39	92	14.9	Төрийн бус байгууллага	46	7.5
40-44	98	15.9	5. Харьяалагдах дүүрэг		
45-49	88	14.3	БГД	204	33.1
50-54	58	9.4	ЧД	134	21.8
55-59	22	3.6	БЗД	278	45.1
60-64	14	2.3	6. Судалгааны объект		
65-с дээш	4	0.6	Орон сууц	200	32.5
3. Боловсролын түвшин			Дүүргийн засаг захиргааны байр	184	29.9
Бүрэн бус дунд	26	4.2	Боловсролын байгууллага	94	15.3
Бүрэн дунд	176	28.6	Үйлчилгээний төв	138	22.4
Дээд	414	67.2			



1.2 ШИЛЭН ДАНС БОЛОН ШИЛЭН ДАНСНЫ НЭГДСЭН ЦАХИМ ХУУДАСНЫ ТАЛААРХ ИРГЭДИЙН ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ


Иргэдээс авсан асуулга судалгаагаар шилэн дансны талаарх иргэдийн ерөнхий ойлголт мэдлэг доогуур байгаа нь харагдлаа. Тухайлбал, судалгаанд хамрагдсан 616 иргэний ихэнх буюу 55.2% нь “бага зэрэг” мэднэ гэсэн байна. Харин 36.7% нь “огт мэдэхгүй” гэсэн бол ердөө 8.1% нь “сайн мэднэ” гэсэн дүнтэй байна (Зураг 1.2.1).

Зураг 1.2.1 Шилэн дансны талаарх иргэдийн ойлголт, мэдлэг (тоогоор, дүнд эзлэх хувиар)



Судалгаанд хамрагдсан иргэдийн зөвхөн 6.2% нь шилэн дансны нэгдсэн цахим хуудаснаас улс, орон нутгийн болон төсвийн байгууллагын төсвийн мэдээлэл авдаг байна (Зураг 1.2.2).


Зураг 1.2.2 Улс, орон нутгийн болон төсвийн байгууллагын төсвийн мэдээллийг иргэд авдаг эх сурвалж (тоогоор, дүнд эзлэх хувиар)



Улс, орон нутгийн болон төсвийн байгууллагын төсвийн мэдээлэл авдаг иргэдийн 32.4% нь тухайн байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбараас авдаг байна. Харин 23.1% нь бусад эх сурвалжууд болох телевиз, хэвлэл мэдээлэл болон цахим хуудаснаас авдаг байна.



Зураг 1.2.3 Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны талаарх иргэдийн ойлголт, мэдлэг (тоогоор, дүнд эзлэх хувиар)



Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны талаарх ойлголтыг тодруулахад судалгаанд хамрагдсан иргэдийн 61.4% нь огт мэдэхгүй байна (Зураг 1.2.3). Харин 32.5% нь бага зэрэг мэддэг бол 6.2% нь сайн мэддэг байна.

1.3 ШИЛЭН ДАНСНЫ НЭГДСЭН ЦАХИМ ХУУДАСНЫ АШИГЛАЛТ

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн өмчит үйлдвэрийн газар, хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани, улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага болон төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч нар төсвийн орлого, зарлага, худалдан авалт, тэдгээрт холбогдох шийдвэрүүд, төслийн явц, санхүүжилт зэрэг мэдээллийг Шилэн дансны тухай хууль, “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын дагуу нийтлэх үүрэгтэй юм. Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны хэрэглэгчийн судалгааны хүрээнд иргэд цахим хуудас дахь аль төрлийн мэдээллийг ямар давтамжтайгаар авдаг болохыг судлалаа.

Судалгаанд хамрагдсан 616 иргэний 11.2% нь аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, иргэдийн талаарх, 8.6% нь төсөл, хөтөлбөрийн төсвийн талаарх мэдээлэл авч байна (Зураг 1.3.1). Иргэдийн 6% нь төрийн өмчит аж ахуйн нэгжийн талаарх, 5.7% нь Засгийн газрын тусгай сангуудын, 5.5% нь яамдын нийтэлсэн мэдээллийг авдаг байна.


Зураг 1.3.1 Шилэн дансны нэгдсэн цахим хуудаснаас иргэд аль байгууллага, этгээдийн төсвийн мэдээлэл авдаг талаарх асуулгын дүн (дүнд эзлэх хувиар)





Судалгаанд хамрагдсан иргэдийн 10.7% нь улсын төсвийн талаар, 6.7% нь Нийгмийн даатгалын сангийн төсвийн талаарх мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаснаас мэдээлэл авдаг байна (Зураг 1.3.2). Иргэдийн 4% нь төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, тайланг авч үздэг байна. Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт, гүйцэтгэл, Засгийн газар, орон нутгийн гадаад болон дотоод зээл, буцалтгүй тусламжийн мэдээллийг иргэдийн 3% нь шилэн дансны нэгдсэн цахим хуудаснаас авдаг байна.

Зураг 1.3.2 Шилэн дансны нэгдсэн цахим хуудаснаас иргэд авдаг мэдээллийн төрөл (дүнд эзлэх хувиар)



“Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын 2.2.4-т зааснаар Сангийн яамнаас улсын төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Хүний хөгжил сангийн төсвийн орлого, зарлага, хөрөнгө оруулалт, төсвийн нэгдсэн үзүүлэлт, нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ, улсын төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл



болон аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, Засгийн газрын гадаадын зээл, тусламжийн ашиглалтын улирлын мэдээ, Засгийн газрын гадаад, дотоод өр, үнэт цаасны талаарх мэдээлэл, улсын төсвийн нэгдсэн үзүүлэлтийг макро эдийн засгийн үзүүлэлт, холбогдох бусад үзүүлэлтүүдтэй уялдуулсан судалгаа, тооцоо болон улсын концессын мэдээллийг тус тус нийтлэх үүрэгтэй юм. Шилэн дансны нэгдсэн цахим хуудас дахь эдгээр мэдээллээс иргэд авдаг эсэхийг бид судлан үзэхэд, Засгийн газрын төсвийн мэдээлэл хэсгээс иргэдийн 8% нь Засгийн газрын гадаад зээл, тусламжийн ашиглалтын мэдээлэл, 6.5% нь Засгийн газрын гадаад, дотоод өрийн мэдээллийн талаар авдаг байна (Зураг 1.3.3). Хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх зорилгоор гаргасан Засгийн газрын гадаад үнэт цаасны мэдээллийг иргэдийн 5.9%, төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор гаргасан Засгийн газрын дотоод үнэт цаасны мэдээллийг 4.5% нь авдаг байна.

Зураг 1.3.3 Шилэн дансны нэгдсэн цахим хуудаснаас иргэд Засгийн газрын төсвийн мэдээлэл авдаг байдал (дүнд эзлэх хувиар)




“Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын 2.2.2-т заасны дагуу нийтлэгдсэн хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалтын мэдээллийг иргэд авч буй байдлыг судлахад, судалгаанд хамрагдсан иргэдийн 12% нь тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалт явуулах журам, тендерийн урилгын талаар мэдээлэл авдаг байна (Зураг 1.3.4). Иргэдийн 4.9% нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг авч үзсэн бол 6.5% нь журмын 2.2.3.7-д заасан худалдан авах



ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүнгийн мэдээллийг авдаг байна.

Зураг 1.3.4 Шилэн дансны нэгдсэн цахим хуудаснаас төсвийн санхүүжилттэй худалдан авалтын ямар мэдээлэл авдаг байдал (дүнд эзлэх хувиар)



“Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын 2.2.3-т зааснаар төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд болон төрийн өмчит үйлдвэрийн газрууд зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн талаарх мэдээлэл, журмын 2.2.3.5 заалтын дагуу тухайн байгууллага хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт, байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт зэрэг мэдээллийг нийтлэх үүрэгтэй. Эдгээр мэдээллийг иргэд ашиглаж буй байдлыг судалж үзэв. Судалгаагаар, иргэдийн 6.2% нь нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалт, тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлттэй холбоотой мэдээлэл авдаг байна (Зураг 1.3.5). Иргэдийн 5.9% нь зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгслийн мэдээлэл авчээ.




Зураг 1.3.5 Шилэн дансны журмын 2.2.3-т заасан мэдээллүүдийг авдаг байдал (дүнд эзлэх хувиар)



Шилэн дансны тухай хуулийн 6.9 дэх заалтын дагуу арван сая төгрөгөөс дээш үнийн дүнгээр улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, санхүүжилттэй төсөл, хөтөлбөр, хэрэгжүүлж буй аж ахуйн нэгж, байгууллага нь төслийн нийт төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийн мэдээллийг улирал бүр шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулах үүрэгтэй. Судалгаанд хамрагдсан иргэдийн 4.6% нь арван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, санхүүжилттэй төсөл, хөтөлбөрийн мэдээллийг авчээ.

Зураг 1.3.6 Шилэн дансны цахим хуудаснаас иргэд мэдээлэл авдаг давтамж (дүнд эзлэх хувиар)



Шилэн дансны цахим хуудаснаас мэдээлэл авдаг иргэдийн 20.5% нь зөвхөн шаардлагатай үед мэдээлэл авдаг байна (Зураг 1.3.6). Иргэдийн 5% нь улирал тутам, 3.6% нь хагас жил тутам мэдээлэл авдаг байна.



1.4 ШИЛЭН ДАНСНЫ НЭГДСЭН ЦАХИМ ХУУДАС, БАЙРШУУЛСАН МЭДЭЭЛЭЛД ӨГӨХ ҮНЭЛГЭЭ

Шилэн дансны цахим хуудаст тавигдах шаардлагуудыг Шилэн дансны тухай хуулийн 5.1-т тусгасан байдаг. Энэхүү заалтын дагуу цахим хуудас нь мэдээлэл татаж авах, хэвлэх боломжтой байх, тодруулга өгөх албан тушаалтны мэдээллийг байршуулах, мэдээллийг тогтмол шинэчилж байх, өөрчлөлт орсон тухай бүр өмнөх мэдээллийг цахим хуудасны архивт хадгалах, архивын мэдээллийн санд нэвтрэх, татаж авах, хэвлэх боломжтой байх гэсэн шаардлагуудыг хангаж буй эсэх талаарх иргэдийг саналыг судалж үзэв. Судалгаанд хамрагдсан иргэдийн 11.1% нь “цахим хуудас дахь мэдээлэл тогтмол шинэчлэгддэг” гэж хариулжээ (Зураг 1.4.1). Иргэдийн 9.4% нь цахим хуудас нь мэдээлэл татаж авах, хэвлэх боломжтой байх шаардлагыг хангаж байна гэж үзсэн байна.

Зураг 1.4.1 Шилэн дансны нэгдсэн цахим хуудас хуулийн шаардлагыг хангаж байгаа эсэх (дүнд эзлэх хувиар)





Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны архивийн мэдээллийн санд нэвтрэх боломжтой байдалд иргэдийн 6.4%, мэдээлэлд өөрчлөлт орсон тухай бүр өмнөх мэдээллийг цахим хуудасны архивт хадгалах байдалд иргэдийн 5% санал өгсөн байна. Судалгаанд оролцсон иргэдийн 4.7% нь цахим хуудас нь архиваас мэдээлэл татаж авах, хэвлэх боломжтой байх, тодруулга өгөх албан тушаалтны нэр, утас, цахим хаягийг байршуулсан байх шаардлагыг хангаж байна гэж үзжээ.

Шилэн дансны тухай хуульд заасан этгээд нь хуулийг хэрэгжүүлэхдээ хуулийн 4.1-т тусгасны дагуу нийтэлсэн мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх, ойлгомжтой, ач холбогдолтой байх, тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх, хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх зэрэг зарчмуудыг баримтлах



үүрэгтэй. Шилэн дансны нэгдсэн цахим хуудас дахь мэдээлэл нь эдгээр зарчмыг хангаж байгаа эсэхэд иргэд “дунд” гэсэн үнэлгээ өгсөн байна. Шилэн дансны цахим хуудаснаас мэдээлэл авдаг иргэдийн 20% нь мэдээллийн иж бүрэн байдлын шаардлагыг хангах байдал “дунд” гэж үзжээ (Зураг 1.4.2). Иргэдийн 18 орчим хувь нь мэдээллийн үнэн зөв, бодитой, ойлгомжтой байдлыг мөн “дунд” гэж үнэлэв. Цаашилбал, нийтэлсэн мэдээллийн ач холбогдолтой байдал, тогтоосон хугацаандаа мэдээлдэг байдал болон хуулийн дагуу нууцад хамруулсанаас бусад бүх мэдээллийг нээлттэй байршуулдаг байдалд иргэдийн 17% нь “дунд” гэсэн үнэлгээ өгчээ.

Зураг 1.4.2 Шилэн дансны нэгдсэн цахим хуудас дахь мэдээлэлд иргэдээс өгсөн үнэлгээ (дүнд эзлэх хувиар)





Шилэн дансны нэгдсэн цахим хуудсыг сайжруулах шаардлагатай эсэх талаарх иргэдийн саналыг судлахад, уг цахим хуудаснаас мэдээлэл авдаг иргэдийн 19.5% нь цахим хуудсыг сайжруулах шаардлагагүй гэж үзсэн байна. Харин иргэдийн 15.9% нь сайжруулах шаардлагатай гэж үзжээ (Зураг 1.4.3).

Зураг 1.4.3 Шилэн дансны нэгдсэн цахим хуудсыг сайжруулах шаардлагатай эсэх талаарх иргэдийн санал (тоогоор, дүнд эзлэх хувиар)



Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны талаар иргэдээс гарсан санал, шүүмжлэлээс дурдвал:

- Шилэн дансны нэгдсэн цахим хуудас руу орж үзээд ойлгомжгүй, мэдээлэл хайх нь хэцүү санагддаг.
- Цахим хуудас дахь мэдээлэл нь дэлгэрэнгүй бөгөөд бүрэн гүйцэд байдаггүй.
- Шилэн дансны архив нь учир дутагдалтай.
- Цахим хуудас нь алдаа дутагдал ихтэй байдаг. Гэвч үүнийг яаж шийдэх, хэнд хандахаа мэдэхгүй зэрэг болно.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсыг дараах байдлаар сайжруулахыг асуулгад оролцсон иргэдийн зүгээс санал болгож байна:

- Шилэн дансны нэгдсэн цахим хуудас дахь мэдээллийн хайлтын системийг сайжруулах
- Цахим хуудсыг илүү ойлгомжтой болгох
- Илүү дэлгэрэнгүй, ойлгомжтой байдлаар график дүрслэл ашиглах;
- Шилэн дансны нэгдсэн цахим хуудас бүхий Application буюу программ боловсруулах;
- Мэдээллийн үнэ зөв байдлыг дээшлүүлэх;
- Архивын чанарыг сайжруулах;
- Байршуулсан мэдээллийн ойлгомжтой, тодорхой байдлыг нэмэгдүүлэх; Тодорхойгүй мэдээллийн талаар дэлгэрэнгүй лавлахтай байх; Мэргэжлийн үг хэллэгийг тайлбартай, илүү ойлгомжтой болгох;
- Бүх төрлийн байгууллагын шилэн данс ил тод, нээлттэй болгох;
- Мэдээллийг шинэчилж, татахад хялбар болгох;
- Мэдээллийг цахим хуудаст шуурхай байрлуулах байдлыг дээшлүүлэх;
- Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэх;



- Тухайн байгууллагаас лавлах, холбоо барих мэдээллийг байршуулах байдлыг нэмэгдүүлэх зэрэг болно.

1.5 ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ИРГЭНИЙ ХЯНАЛТ

Шилэн дансны тухай хуулийн гол зорилго нь төсвийн мэдээллийг олон нийтэд нээлттэй болгож, төсвийн удирдлагад иргэдийн хяналтыг бий болгох явдал юм. Иймд бид иргэд уг хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж байгаа эсэхийг судлаж үзэхэд, шилэн дансны нэгдсэн цахим хуудасны талаар ойлголт, мэдлэг бүхий иргэдийн 22.4% нь төсвийн захиран зарцуулалттай танилцах зорилгоор, 10.4% нь төсвийн захиран зарцуулалтад хяналт тавих зорилгоор мэдээлэл авдаг байна (Зураг 1.5.1). Мөн түүнчлэн иргэд хөрөнгө оруулалтын талаар мэдээлэл авах, судалгаа, эрдмийн бүтээлд хоёрдогч өгөгдөл болгон мэдээлэл авдаг байна.

Зураг 1.5.1 Шилэн дансны мэдээллийг иргэд ямар зорилгоор авдаг талаар (тоогоор, дүнд эзлэх хувиар)



Судалгаанд хамрагдсан иргэдийн 10 нь буюу 1.6% нь Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилийн явц, зөрчлийн талаар гомдол болон шаардлага гаргаж байсан байна (Зураг 1.5.2). Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой байгууллага, албан тушаалтанд гаргасан эдгээр гомдол, шаардлагын 4-ийг нь шийдвэрлэж, 6 удаагийн гомдлыг шийдвэрлээгүй байна.

Зураг 1.5.2 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн явц, зөрчлийн талаар иргэд гомдол, шаардлага гаргаж байсан байдал (тоогоор, дүнд эзлэх хувиар)





II. ХОЁР ТАЛТ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны хэрэглэгчийн санал асуулгын судалгааны дүнг судалгаанд оролцогсдын ерөнхий мэдээлэл буюу нас, хүйс, боловсролын түвшин, ажил эрхлэлтийн байдал зэргээр ангилан харьцуулсан 2 талт судалгааны дүнг дор тайлагнаж байна.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны талаарх ойлголт, мэдлэгийг үнэлэх судалгаанд 616 иргэд хамрагдсанаас 6.2% буюу 38 иргэн сайн мэднэ гэж тодорхойлсон. Эдгээр иргэдийг насны ангилалаар авч үзвэл 24 иргэн нь 25-39 насных байна (Хүснэгт 2.1).

Хүснэгт 2.1 Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны талаарх иргэдийн ойлголт, мэдлэгийг насаар ангилсан байдал

		Нас										нийт
		20-24	25-29	30-34	35-39	40-44	45-49	50-54	55-59	60-64	65-с дээш	
Сайн мэднэ	тоо	4	10	6	8	2	6	0	0	0	2	38
	хувь	,6%	1,6%	1,0%	1,3%	,3%	1,0%	0,0%	0,0%	0,0%	,3%	6,2%
Бага зэрэг мэднэ	тоо	30	30	38	22	36	28	12	2	2	0	200
	хувь	4,9%	4,9%	6,2%	3,6%	5,8%	4,5%	1,9%	,3%	,3%	0,0%	32,5%
Огт мэдэхгүй	тоо	32	44	46	62	60	54	46	20	12	2	378
	хувь	5,2%	7,1%	7,5%	10,1%	9,7%	8,8%	7,5%	3,2%	1,9%	,3%	61,4%
нийт	тоо	66	84	90	92	98	88	58	22	14	4	616
	хувь	10,7%	13,6%	14,6%	14,9%	15,9%	14,3%	9,4%	3,6%	2,3%	,6%	100,0%

Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны талаарх “сайн мэднэ” гэж хариулсан 38 иргэний 20 нь эмэгтэй байна (Хүснэгт 2.2).

Хүснэгт 2.2 Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны талаарх иргэдийн ойлголт, мэдлэгийг хүйсээр ангилсан байдал

		Хүйс		нийт
		эрэгтэй	эмэгтэй	
Сайн мэднэ	тоо	18	20	38
	хувь	2,9%	3,2%	6,2%
Бага зэрэг мэднэ	тоо	100	100	200
	хувь	16,2%	16,2%	32,5%
Огт мэдэхгүй	тоо	158	220	378
	хувь	25,6%	35,7%	61,4%
нийт	тоо	276	340	616
	хувь	44,8%	55,2%	100,0%



Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны талаарх ойлголт, мэдлэгийг боловсролын түвшингээр ангилаж харвал нэгдсэн цахим хуудасны талаарх ойлголт, мэдлэг сайн гэсэн 38 иргэний 85 орчим хувь буюу 32 иргэн нь дээд боловсролтой байна (Хүснэгт 2.3).

Хүснэгт 2.3 Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны талаарх иргэдийн ойлголт, мэдлэгийг боловсролын түвшингээр ангилсан байдал

		Боловсрол			нийт
		Бүрэн бус дунд	Бүрэн дунд	Дээд	
Сайн мэднэ	тоо	0	6	32	38
	хувь	0,0%	1,0%	5,2%	6,2%
Бага зэрэг мэднэ	тоо	2	28	170	200
	хувь	,3%	4,5%	27,6%	32,5%
Огт мэдэхгүй	тоо	24	142	212	378
	хувь	3,9%	23,1%	34,4%	61,4%
нийт	тоо	26	176	414	616
	хувь	4,2%	28,6%	67,2%	100,0%

Судалгаанд хамрагдсан иргэдээс Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны талаар сайн мэдэх иргэдийн 80 орчим хувь нь төрийн байгууллагын болон хувийн хэвшлийн байгууллагын ажилтнууд байна (Хүснэгт 2.4).

Хүснэгт 2.4 Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны талаарх иргэдийн ойлголт, мэдлэгийг ажил эрхлэлтийн байдлаар ангилсан байдал

		Ажил эрхлэлт							нийт
		Төрийн байгууллага	Хувиараа хөдөлмөр эрхлэгч	Хувийн хэвшил	Олон улсын байгууллага	Ажилгүй	Оюутан	Төрийн бус байгууллага	
Сайн мэднэ	тоо	12	4	18	2	2	0	0	38
	хувь	1,9%	,6%	2,9%	,3%	,3%	0,0%	0,0%	6,2%
Бага зэрэг мэднэ	тоо	46	30	84	2	8	6	24	200
	хувь	7,5%	4,9%	13,6%	,3%	1,3%	1,0%	3,9%	32,5%
Огт мэдэхгүй	тоо	54	94	140	2	44	22	22	378
	хувь	8,8%	15,3%	22,7%	,3%	7,1%	3,6%	3,6%	61,4%
нийт	тоо	112	128	242	6	54	28	46	616
	хувь	18,2%	20,8%	39,3%	1,0%	8,8%	4,5%	7,5%	100,0%

Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны талаарх ойлголт, мэдлэгийг иргэдийн харьяаллаар ангилаж харвал нэгдсэн цахим хуудасны талаарх ойлголт, мэдлэг сайн гэсэн 38 иргэний 85 орчим хувь нь Баянгол болон Баянзүрх дүүргүүдийн иргэд байна (Хүснэгт 2.5).



Хүснэгт 2.5 Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны талаарх иргэдийн ойлголт, мэдлэгийг дүүргээр ангилсан байдал

	Дүүрэг				нийт
		БГД	ЧД	БЗД	
Сайн мэднэ	тоо	16	6	16	38
	хувь	2,6%	1,0%	2,6%	6,2%
Бага зэрэг мэднэ	тоо	62	40	98	200
	хувь	10,1%	6,5%	15,9%	32,5%
Огт мэдэхгүй	тоо	126	88	164	378
	хувь	20,5%	14,3%	26,6%	61,4%
нийт	тоо	204	134	278	616
	хувь	33,1%	21,8%	45,1%	100,0%



II. ДҮГНЭЛТ

Шилэн дансны тухай хуулийн дагуу Засгийн газраас шилэн дансны нэгдсэн цахим хуудсыг бий болгон улс, орон нутгийн төсвийн орлого, зарлага, худалдан авалт, холбогдох шийдвэр зэрэг мэдээллүүдийг нийтэд ил болгох үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Үндэсний Аудитын Газартай байгуулсан гэрээний дагуу Нээлттэй нийгэм форумаас иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран шилэн дансны нэгдсэн цахим хуудасны хэрэглэгчийн санал асуулгын судалгааг нийслэлийн 3 дүүргийн 600 гаруй иргэнийг хамруулан хийлээ.

Нийслэлийн Баянгол, Баянзүрх, Чингэлтэй дүүргийн иргэдийн дунд хийсэн энэхүү судалгааны дүнгээр шилэн дансны нэгдсэн цахим хуудасны талаар иргэдийн мэдлэг, мэдээлэл дутмаг байгаа нь харагдав. Тухайлбал, судалгаанд хамрагдсан иргэдийн 55% нь шилэн дансыг “бага зэрэг мэднэ”, гэж хариулсан бол зөвхөн 8% нь “сайн мэднэ” гэжээ. Цаашилбал, Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны талаар иргэдийн 32.5% нь “бага зэрэг мэднэ”, гэсэн бол зөвхөн 6% нь “сайн мэднэ” гэжээ. Судалгаанд хамрагдсан иргэдийн зөвхөн 6% нь улс, орон нутгийн болон төсвийн байгууллагын төсвийн талаарх мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаснаас авдаг байна. Шилэн дансны цахим хуудаснаас мэдээлэл авдаг иргэд мэдээлийн үнэн зөв, бодитой, иж бүрэн байдал, ойлгомжтой, ач холбогдолтой байдал, тогтоосон хугацаандаа мэдээлдэг байдал болон хуулийн дагуу нууцад хамруулсанаас бусад бүх мэдээллийг нээлттэй байршуулж буй байдалд “дунд” гэсэн үнэлгээ өгсөн байна. Судалгаанд хамрагдсан иргэдийн 1.6% нь Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилийн явц, зөрчлийн талаар гомдол болон шаардлага гаргаж байсан байна.

Судалгааны дүнгээс харахад, төсвийн удирдлагад олон нийт хяналт тавих үйл ажиллагааг дээшлүүлэхийн тулд Шилэн дансны тухай хууль болон шилэн дансны нэгдсэн цахим хуудсыг иргэдэд таниулах ажлыг төр засгийн зүгээс хийх шаардлагатай байна. Мөн цахим хуудсанд байршуулсан мэдээллийн ойлгомжтой байдлыг дээшлүүлэх, мэдээллээ шинэчилж, татаж авахад хялбар болгох хэрэгтэй байна.



ШИЛЭН ДАНСНЫ НЭГДСЭН ЦАХИМ ХУУДАСНЫ ХЭРЭГЛЭГЧИЙН САНАЛ АСУУЛГА

ЭРХЭМ ТАНД ЭНЭ ӨДРИЙН МЭНД ХҮРГЬЕ

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО: Улс, орон нутгийн төсөв, улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх зорилго бүхий Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн мэдээллийг нийтлэх Шилэн дансны нэгдсэн цахим хуудас (<http://shilendans.gov.mn>) болон түүнд байршуулсан мэдээлэл нь иргэдэд ойлгомжтой, ач холбогдолтой байгаа эсэх, мэдээлэлтэй иргэд танилцаж, төсвийн хяналтыг хэрэгжүүлж байгаа эсэхийг тодорхойлоход оршино.

Санал асуулгыг бөглөх заавар

Та асуултанд хариулахдаа өөрийн сонгосон хариултын өмнөх дугаарыг дугуйлна уу.

I. ШИЛЭН ДАНС БОЛОН ШИЛЭН ДАНСНЫ НЭГДСЭН ЦАХИМ ХУУДАСНЫ ТАЛААРХ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

1.1. Та Шилэн дансны талаар хэр мэдэх вэ?

- a. Сайн мэднэ
- b. Бага зэрэг мэднэ
- c. Огт мэдэхгүй

1.2. Улс, орон нутгийн болон төсвийн байгууллагын төсвийн мэдээллийг та хаанаас авдаг вэ?

- a. Шилэн дансны нэгдсэн цахим хуудаснаас
- b. Тухайн байгууллагын цахим хуудаснаас
- c. Тухайн байгууллагын мэдээллийн самбараас
- d. Бусад эх сурвалжаас/ эх сурвалжийг бичнэ үү/
- e. Мэдээлэл авдаггүй

1.3. Та Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны талаар хэр мэдэх вэ?

- a. Сайн мэднэ
- b. Бага зэрэг мэднэ
- c. Огт мэдэхгүй /5-р хэсэг дэх Ерөнхий мэдээлэл хэсгийг бөглөнө үү/



II. ШИЛЭН ДАНСНЫ НЭГДСЭН ЦАХИМ ХУУДАСНЫ АШИГЛАЛТ

2.1. Та Шилэн дансны нэгдсэн цахим хуудаснаас ямар байгууллага, этгээдийн төсвийн мэдээлэл авдаг вэ?

- a. Төсвийн ерөнхийлөн захирагчийн нийтэлсэн мэдээлэл
- b. Яамдын нийтэлсэн мэдээлэл
- c. Агентлагийн нийтэлсэн мэдээлэл
- d. Төрийн өмчит аж ахуйн нэгжийн нийтэлсэн мэдээлэл
- e. Төсөл, хөтөлбөрийн мэдээлэл
- f. Аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, иргэдийн мэдээлэл
- g. Засгийн газрын тусгай сангуудын мэдээлэл

2.2. Та Шилэн дансны нэгдсэн цахим хуудаснаас аль төрлийн мэдээлэл авдаг вэ?

- a. Улсын төсөв (батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэл, дараа жилийн төсвийн төсөл)
- b. Орон нутгийн төсөв (батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэл)
- c. Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, тайлан
- d. Нийгмийн даатгалын сангийн төсөв;
- e. Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт, гүйцэтгэл
- f. Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар
- g. Засгийн газрын тусгай сан;
- h. Засгийн газар, орон нутгийн өрийн бичиг, санхүүгийн бусад хэрэгсэл;
- i. Засгийн газар, орон нутгийн гадаад болон дотоод зээл, буцалтгүй тусламж;
- j. Төр, хувийн хэвшлийн түншлэл, концесс;
- k. Засгийн газар, орон нутгийн баталгаа болон төсвийн өр, авлага үүсгэх аливаа бусад шийдвэр.
- l. Төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан, дүгнэлт
- m. Аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан

2.3. Та Шилэн дансны нэгдсэн цахим хуудаснаас Засгийн газрын төсвийн дараах мэдээллүүдээс авдаг уу?

- a. Засгийн газрын гадаад зээл, тусламжийн ашиглалтын мэдээ
- b. Засгийн газрын гадаад, дотоод өрийн мэдээлэл
- c. Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор гаргасан Засгийн газрын дотоод үнэт цаасны мэдээлэл
- d. Хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх зорилгоор гаргасан Засгийн газрын гадаад үнэт цаасны мэдээлэл
- e. Концессын зүйлийн жагсаалт болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт
- f. Концессын гэрээ болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт
- g. Концессын зүйл, гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээлэл
- h. Улсын төсвийн нэгдсэн үзүүлэлтийг макро эдийн засгийн үзүүлэлт, холбогдох бусад үзүүлэлттэй уялдуулсан судалгаа, тооцоо
- i. Энэ хэсгээс мэдээлэл авдаггүй



2.4. Та Шилэн дансны нэгдсэн цахим хуудаснаас төсвийн санхүүжилттэй худалдан авалтын аль төрлийн мэдээллийг авдаг вэ?

- a. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;
- b. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө,
- c. Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан;
- d. Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн;
- e. Энэ хэсгээс мэдээлэл авдаггүй

2.5. Та Шилэн дансны нэгдсэн цахим хуудаснаас дараах мэдээллүүдээс авдаг уу?

- a. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;
- b. Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт;
- c. Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт;
- d. Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;
- e. Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалтыг тухайн этгээдийн нэр
- f. Арван сая төгрөгөөс дээш үнийн дүнгээр улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага болон төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгчийн гүйцэтгэж буй ажил, үйлчилгээний нийт төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийн мэдээлэл
- g. Энэ хэсгээс мэдээлэл авдаггүй

2.6. Та Шилэн дансны нэгдсэн цахим хуудаснаас мэдээлэл ямар давтамжтайгаар авдаг вэ?

- a. Өдөр тутам
- b. 7 хоног тутам
- c. 14 хоног тутам
- d. Сар тутам
- e. Улирал тутам
- f. Хагас жил тутам
- g. Жил тутам
- h. Шаардлагатай үед



III. ШИЛЭН ДАНСНЫ НЭГДСЭН ЦАХИМ ХУУДАС, БАЙРШУУЛСАН МЭДЭЭЛЭЛД ӨГӨХ ҮНЭЛГЭЭ

3.1. Шилэн дансны нэгдсэн цахим хуудас дараах шаардлагыг хангаж байна уу?

- Мэдээлэл татаж авах, хэвлэх боломжтой байх;
- Тодруулга өгөх албан тушаалтны нэр, утас, цахим хаягийг байршуулсан байх;
- Мэдээллийг тогтмол шинэчилж байх;
- Мэдээлэлд өөрчлөлт орсон тухай бүр өмнөх мэдээллийг цахим хуудасны архивт хадгалах;
- Архивын мэдээллийн санд нэвтрэх боломжтой байх;
- Архивын мэдээллийг татаж авах, хэвлэх боломжтой байх;

3.2. Та Шилэн дансны цахим систем дахь мэдээлэлд ямар үнэлгээ өгөх вэ?

	Санал нийлэх хэсэгт + тэмдэглэгээ хийнэ үү				
	Маш муу	Муу	Дунд	Сайн	Маш сайн
a. Мэдээллийн үнэн зөв, бодитой, байдал					
b. Мэдээллийн иж бүрэн байдал					
c. Мэдээллийн ойлгомжтой байдал					
d. Мэдээллийн ач холбогдолтой байдал					
e. Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байдал					
f. Хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээллийн нээлттэй байдал					

3.3. Та Шилэн дансны нэгдсэн цахим хуудсыг сайжруулах шаардлагатай гэж үзэж байна уу?

- Тийм - Шилэн дансны нэгдсэн цахим хуудсыг хэрхэн сайжруулах талаар танд санал байгаа бол доор бичнэ үү.
.....
.....
.....
- Үгүй

IV. ШИЛЭН ДАНСНЫ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ИРГЭНИЙ ХЯНАЛТ



4.1. Та Шилэн дансны мэдээллийг ямар зорилгоор авдаг вэ?

- a. Төсвийн захиран зарцуулалттай танилцаж мэдээлэл авах
- b. Төсвийн захиран зарцуулалтад хяналт тавих
- c.

4.2. Та Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн явц, шилэн дансны мэдээллийн зөрчил, дутагдлын талаар байгууллага, албан тушаалтан, төрийн аудит болон захиргааны хэргийн шүүхэд гомдол болон шаардлагыг гаргаж байсан уу?

- a. Тийм
- b. Үгүй /Үгүй бол ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ хэсгийг бөглөнө үү/

4.3 Хэрэв гомдол болон шаарлага гаргаж байсан бол аль түвшинд шийдвэрлэж байсан бэ?

Шийдвэрлэсэн түвшин	1.Хаана гомдол гаргасан бэ? Сонгоно уу.	2.Шийдвэрлэсэн эсэх	
		тийм	үгүй
Байгууллага, албан тушаалтан			
Төрийн аудит			
Захиргааны хэргийн шүүх			

4.4 Шилэн дансны хуулийг зөрчсөн албан тушаалтан хариуцлага хүлээсэн үү?

- a. Тийм
- b. Үгүй

V. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Таны хүйс	☐ эрэгтэй	☐ эмэгтэй
Таны нас	☐ 20-24 ☐ 25-29 ☐ 30-34 ☐ 35-39 ☐ 40-44 ☐ 45-49 ☐ 50-54 ☐ 55-59 ☐ 60-64 ☐ 65-с дээш	
Таны боловсрол	☐ Бүрэн бус дунд ☐ Бүрэн дунд ☐ Дээд	
Таны ажил эрхлэлт	☐ Төрийн байгууллага ☐ Хувиараа хөдөлмөр эрхлэгч ☐ Хувийн хэвшил ☐ Олон улсын байгууллага ☐ Ажилгүй ☐ Оюутан ☐ Төрийн бус байгууллага ☐ Бусад.....	



Судалгаа авах явцад гарсан бэрхшээл, асуудлууд

Иргэдээс асуулгын судалгаа авах явцад гарсан бэрхшээл, асуудлуудыг тоймловол:

- Иргэдэд шилэн дансны тухай ойлголт хангалтгүй тул асуулгыг бөглөж өгөхөөс татгалзах тохиолдол нэлээд гарч байсан.
- Судалгааны асуулга олон байгаа нь иргэдээс асуулга авахад хүндрэлтэй байсан.
- Орон сууцны иргэдээс бүсүүдийн харьяалагдах айл өрхүүдийн хаалгыг тогшин судалгаа бөглөж өгөхийг хүсэхэд “тийм зүйл мэдэхгүй”, “бөглөж өгөхгүй”, “чадахгүй” зэргээр хариулж байсан ба нааштай хүлээж авсан иргэдийн мэдлэг, ойлголт дутмаг байсан.
- Худалдаа үйлчилгээ эрхэлж буй хүмүүсийн хувьд “шилэн данс гэж юу вэ?” гэх үндсэн ойлголтыг бага зэрэг мэдэхээс биш улсын хэмжээний шилэн дансны зохицуулалтыг хувийн зүгээс нарийвчлан судалж байсан удаагүй бөгөөд “уг судалгааг бөглөснөөр улс орны эдийн засагт хэрхэн өөрчлөлт оруулах юм бэ?” гэсэн асуултыг бухимдсан байдлаар асууж байсан.
- Нийгэмд байгаа иргэдийн бухимдал судалгааны явцад хүндрэл үзүүлж байлаа.



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

Хаяг: Жамъян гүний гудамж 5/1, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар 14240, Монгол Улс

Утас: 976-11-313207 Факс: 976-11-324857 E-mail: osf@forum.mn

<http://www.forum.mn>